



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

2024



75114444, 77006768



www.basaltwool.mn



monbasalt@rockwool.mn



Агуулга

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ

Компанийн танилцуулга

Үйл ажиллагааны тайлангийн тойм

Санхүүгийн тайлангийн тойм

Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тойм

Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт

Ногдол ашгийн мэдээлэл

Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл

Компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого

2024 оны төлөвлөгөөт ажлын тойм

Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудас

Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл





“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн оноосон нэр: “Монгол базальт” хувьцаат компани

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн тойруу-132 тоот

Хурал болох газар: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-15 хаягт байрлах Туушин зочид буудлын 4 давхарт, “Сүлд” танхимд

Хурал болох өдөр, цаг: 2024 оны 04 сарын 29-ний өдрийн Даваа гаригт 15.00 цагт

Хурал болох хэлбэр: Танхим

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр:
2024 оны 04 сарын 12-ны өдөр

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. “Монгол базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах
2. “Монгол базальт” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж, батлах
3. “Монгол базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого хэлэлцэж, батлах

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:

1. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хөтөлбөр
3. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан
4. Компанийн 2023 оны санхүүгийн тайлан
5. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт
6. Ногдол ашиг тараах тухай ТУЗ-ийн тогтоол
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудас

Эрхэм хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын материалтай 2024 оны 03 сарын 27-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд **10.00-16.00** цагийн хооронд өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани болон Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, “Фламинго тауэр”-ийн 7 давхарт компанийн төв оффисын аль нэгт очиж эсхүл www.basaltwool.mn цахим хуудсаар дамжуулан танилцах боломжтой.

Дэлгэрэнгүй мэдээллийг **75114444** утсаар авч болно.

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС



МОНГОЛ БАЗАЛТЫТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 19-ны өдөр

№ 04

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дах заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2, 6.3, 6.4 дэх хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 3 дугаар сарын 19-ны өдрийн тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2024 оны 04 сарын 29-ны өдрийн Даваа гаригийн 15.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-15 тоот хаягт байрлах Туушин зочид буудлын “Сүлд танхим”-д танхимын хэлбэрээр зарлан хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- “Монгол базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах

- “Монгол базальт” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийг хэлэлцэж, батлах

- “Монгол базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого хэлэлцэж, батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 03 сарын 22-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 сарын 12-ны өдрөөр тогтоосугай.

5. “Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, Компанийн цахим хуудас болон өдөр тутмын “Өдрийн сонин”-оор 2024 оны 03 сарын 24-ний өдөр олон нийтэд мэдээлж, зарын давталтыг 2024 оны 04 сарын 08-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гаргах шийдвэрийн төсөл, танилцуулга зэрэг баримт бичгийг 2024 оны 03 сарын 26-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарын загварыг нэгдүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, хурлын саналын хуудасны загварыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг, хурлын хөтөлбөрийг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2024 оны 04 сарын 26-ний өдрийн 18.00 цаг хүртэл хугацаанд брокер дилерийн компаниар дамжуулан эсхүл Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр 7 давхарт байрлах компанийн төв оффист бичгээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг хурал зохион байгуулах комиссын дарга /П.Нямдорж/-д даалгасугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Нямдорж, хурал зохион байгуулах комиссын гишүүдээр О.Билгүүн, Ц.Мэндбаяр нарыг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Т.Ууганцэцэг, тооллогын комиссын гишүүдээр Б.Амаржаргал, Э.Цэрэнпагма нарыг томилсугай.

12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжид зааснаар Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 19-ны өдрийн
04 дүгээр тогтоолын хоёрдугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн нэр
1	"Монгол базальт" ХК-ийн ТУЗ-ийн тогтоол, хавсралтуудын хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай 2024.03.19-ны өдрийн Дугаар 04
2	"Монгол базальт" ХК-ийн 2023 оны Санхүүгийн тайлан "Нексия глобал монголиа аудит" ХХК-ийн хөндлөнгийн аудитын дүгнэлт
3	"Монгол базальт" ХК-ийн 2023 оны Үйл ажиллагааны тайлан
4	"Монгол базальт" ХК-ийн 2023 оны Үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлт
5	"Монгол базальт" ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого
6	Монгол базальт" ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл
7	Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан
8	Төлөөлөн удирдах зөвлөлийн Ногдол ашиг тараах тухай 2024.02.16-ны өдрийн Дугаар 03 тогтоол
9	Компанийн 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид, түүний хувьцааны төрөл, тоо



**“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХӨТӨЛБӨР**

Нийт үргэлжлэх хугацаа: 3 цаг

Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
14.45-15.00	Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг бүртгэх	Хурал зохион байгуулах комисс
15.00-15.05	Тооллогын комисс хурлын ирцийг танилцуулах	Тооллогын комисс дарга
15.05-15.10	Хурлын үйл ажиллагааг нээж, дэгийг танилцуулах	Хурлын дарга П.Нямдорж
15.10-15.30	Монгол базальт ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах	Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл
15.30-15.45	ТУЗ-ийн үйл ажиллагаа болон компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан, аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-өөс өгсөн дүгнэлт танилцуулах	ТУЗ-ийн гишүүн Б.Шаравсамбуу
15.45-15.50	Ногдол ашиг хуваарилсан тухай ТУЗ-ийн тогтоол, статистик танилцуулах	Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл
16.50-16.00	Компанийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлтийн төсөл танилцуулах	Гүйцэтгэх захирал А.Энхгэрэл
16.00-16.10	Ажилтнуудыг хувьцаажуулах хөтөлбөрийг танилцуулах	ТУЗ-ийн гишүүн П.Нямдорж
16.10-16.30	Цайны завсарлага	
16.30-16.40	Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр цахим систем ашиглан санал өгөх талаарх дэлгэрэнгүй танилцуулах	Хурлын дарга П.Нямдорж
16.40-17.00	Монгол базальт ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого танилцуулах	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Л.Ариунболд
17.00-17.15	Асуулт, хариулт	
17.15-17.30	Санал хураалт	Тооллогын комисс
17.30-17.35	Санал хураалтыг нэгтгэн тоолох	Тооллогын комисс
17.35-17.40	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комиссын дарга Т.Ууганцэцэг
17.40-17.45	Хурлаас гарсан шийдвэрийг танилцуулж, хурал хаах	Хурлын дарга П.Нямдорж



ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1. Нийтлэг үндэслэл

1.1 Монгол базальт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн холбогдох дүрэм журам, заавар, компанийн дүрэм болон энэхүү дэгийг баримтлан зохион байгуулна

2. Хурлын дарга, түүний эрх үүрэг

2.1 Хурлын дарга нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай шийдвэр эсхүл хурлын даргыг томилсон шийдвэрт заасан этгээд байна.

2.2 Хурлын дарга дараах эрх, үүрэгтэй. Үүнд:

2.2.1 Хурлын дарга нь хурлын дэгийн дагуу удирдан явуулж, хуралд оролцогчдоос хурлын дэгийг сахин биелүүлэхийг шаардах

2.2.2 Хуралд оролцогчдод асуулт асуух зөвшөөрөл олгож, асуулт асуух хугацааг чанд мөрдүүлэх

2.2.3 Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд энэхүү дэгийн 7-д заасан хариуцлага тооцох

3. Хуралдаанд оролцох

3.1 Хуралд оролцогч нь хурал эхлэхээс 30 минутын өмнө бэлтгэлээ хангаж, бүртгэлээ баталгаажуулсан байна.

3.2 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч иргэн нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн хүчин төгөлдөр иргэний үнэмлэхтэй ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийг авч ирнэ.

3.3 Хуралд оролцогч хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага нь танхимаар хуралд оролцохоор ирэхдээ өөрийн компанийн хүчин төгөлдөр гэрчилгээ /эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/-тай ирнэ. Хэрэв итгэмжлэлийн үндсэн дээр өөрийн төлөөний хүнийг оролцуулах тохиолдолд хүчин төгөлдөр итгэмжлэлийн эх хувийг авчирна.

3.4 Хуралд оролцогчийг дараах тохиолдолд хуралд оролцуулахгүй, хурлын танхимаас гаргана. Үүнд:

3.4.1 Хувьцаа эзэмшигч биш байх

3.4.2 Хувьцаа эзэмшигчийн хуралд оролцох эрхтэйг гэрчлэх бичиг баримтгүй байх

3.4.3 Хүчин төгөлдөр бичиг баримтын шаардлага хангаагүй байх

3.4.4 Хурлын үеэр эмх, замбараагүй байдал бий болгох

3.4.5 Хурлын даргын сануулгыг удаа дараа зөрчих

3.4.6 Зүй бус үг хэллэг хэрэглэх, бусдыг дайрч доромжлох үйлдэл гаргах

3.5 Тооллогын комисс нь энэхүү дэгийн 3.4-т заасан үндэслэлээр тухайн этгээдийг хуралд оруулахгүй, хурлын танхимаас гаргана.

4.1. Асуулт, хариулт

- 4.1 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудалтай холбоотой асуулт асууна. Асуулт асуух хугацаа 1 /нэг/ минут байна.
- 4.2 Хурлын дарга нь хэлэлцэх асуудлыг танилцуулсны дараа хуралд оролцогчдоос асуулт байгаа эсэхийг асууна.
- 4.3 Хурал зохион байгуулагч нь асуулт асуух, хувьцаа эзэмшигчдийг дараалалд оруулан овог, нэр асуултыг тэмдэглэж авна.
- 4.4 Асуултад компанийн эрх бүхий албан тушаалтан хариулна. Асуултад хариулах этгээд нь хэлэлцэх асуудалтай холбоогүй асуултад хариулахаас татгалзах эрхтэй.
- 4.5 Асуулт асуух хугацаа хэтэрсэн тохиолдолд хурлын дарга хугацаа дууссаныг сануулах бөгөөд сануулснаас хойш 30 секунд өнгөрмөгц хурлын дарга тухайн хүнийг асуултаа дуусгахыг шаардана.
- 4.6 Хувьцаа эзэмшигчид нь хуралд оролцож буй хөндлөнгийн аудитын байгууллагын төлөөлөгчөөс асуулт асууж болох ба энэхүү дэгийг баримтална.
- 4.7 Асуултад хариулж дууссаны дараа хурал зохион байгуулах комисс асуултуудыг цаасан болон цахим хэлбэрээр цуглуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

5. Хэлэлцэх асуудалтай холбоотой санал өгөх

- 5.1 Хуралд оролцогч нь хурлын өмнө цахим бүртгэлд бүртгүүлэн, санал өгөх заавартай танилцсан байх бөгөөд тус заавар маягтын дагуу саналаа өгөөгүй бол тухайн саналыг хүчингүйд тооцно.
- 5.2 Урьдчилсан санал гэдэг нь хувьцаа эзэмшигчийн хурлын товлосон өдрөөс өмнө батлагдсан саналын хуудсаар цаасаар өгсөн хувьцаа эзэмшигчийн санал байна.
- 5.3 Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах албан ёсны зарлалд тусгагдсан бүртгэлийн өдрөөс эхлэн урьдчилсан санал өгч болно. Урьдчилсан санал өгсөн тохиолдолд түүнийг дахин өөрчлөхгүй ба тус санал нь эцсийнх байна.
- 5.4 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр өөр агуулгатай санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар түрүүлж өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 5.5 Хуралд оролцогч нь хэлэлцэх асуудал тус бүрт нэг санал өгөх эрхтэй.
- 5.6 Хэлэлцэх асуудлын баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд санал өгөхдөө саналын хуудасны арын хэсэгт бичнэ.
- 5.7 Хуралд оролцогчоос баримт бичгийн төсөл болон тогтоолын төсөлд өгсөн саналыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь саналын товъёогт тусгана. Саналын товъёогт тусгахдаа тухайн хуралд оролцогчийн овог, нэр оруулах саналыг үнэн зөв, бүрэн гүйцэт тусгана.

6. Санал тоолох, саналыг нэгтгэн танилцуулах

- 6.1 Саналыг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилогдсон тооллогын комисс тоолж, нэгтгэнэ.
- 6.2 Тооллогын комиссын дарга нь саналыг нэгтгэж хурлын даргад танилцуулна.
- 6.3 Хуралд оролцогч нь цахим болон цаасан хэлбэрээр давхар санал өгсөн тохиолдолд цаг хугацааны дарааллаар сүүлийн өгсөн саналыг хүчинтэйд тооцно.
- 6.4 Урьдчилсан байдлаар саналаа өгсөн хувьцаа эзэмшигчийн тус хуралд оролцсонд тооцож бүртгэх ба саналын хуудасыг нэгтгэн тоолно.
- 6.5 Тооллогын комисс нь цахим системээр өгсөн саналыг шууд тоолж, цаасан хэлбэрээр өгсөн хүчин төгөлдөр саналыг цахим систем рүү оруулж, саналыг нэгтгэнэ.
- 6.6 Нийт саналыг нэгтгэсэн цахим системийн тайлан болон цаасан хэлбэрээр өгсөн саналыг хамт Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгч, бусад хурлын материалын хамт архивлана.

7. Хариуцлага

- 7.1 Хуралдааны дэг зөрчигчид хуралдаан даргалагч нь эхний удаа сануулна
- 7.2 Удаа дараа зөрчвөл хурлын танхимаас гаргана.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчдээ,

Монгол Базальт ХК-ийн сүүлийн нэг жилийн хугацаанд гаргасан томоохон ололт амжилтыг би та бүхэнд маш их бахархал, урам зоригтойгоор танилцуулж байна. Тогтвортой хөгжил, дэвшилтэт технологи, зах зээлд манлайлах амлалтдаа бид гайхалтай ахиц дэвшил гаргасан.

ESG ба SDG интеграци

Бид байгаль орчин, нийгэм, засаглалд үзүүлэх нөлөөллийн талаар үнэ цэнэтэй ойлголттой болж, ESG-ийн анхны суурь шинжилгээг амжилттай хийж дуусгалаа. Цаашилбал, Тогтвортой хөгжлийн зорилтуудыг (ТХЗ) бодлогодоо нэгтгэх нь уур амьсгалын үйл ажиллагаа, тогтвортой хот, олон нийт, хариуцлагатай хэрэглээ, үйлдвэрлэл зэрэг дэлхийн сорилтуудыг шийдвэрлэх бидний хичээл зүтгэлийг харуулах юм.

Хамтын ажиллагаа, үйлдвэрлэлийн шинэчлэл

ЕСБХБ-ны Олон улсын зөвлөх хөтөлбөртэй хамтран ажилласнаар үйлдвэрлэлийн хүчин чадлаа хоёр дахин нэмэгдүүлж, дулаалгын материалын үнийг 35%-иар бууруулж, зах зээлийн өрсөлдөх чадварыг бэхжүүлсэн. Тогтвортой байдлын төлөөх бидний амлалт нь хариуцлагатай үйлдвэрлэл, ISO стандартыг дагаж мөрдсөнөөр нотлогдож байна.

Орлогын өсөлт ба өргөтгөлийн төлөвлөгөө

2023 оны орлого өмнөх жилээс 20 орчим хувиар бууралттай харагдаж байгаа хэдий ч, энэ нь бүтээгдэхүүнийхээ үнэ өртгийг 35 гаруй хувиар хямдруулсантай холбоотойг дурьдах нь зүйтэл болов уу.

Бид сүүлийн 5 жил жилийн орлогын тогтвортой өсөлтийг 25%-иас дээш байлгаж чадсандаа бахархаж байгаа бөгөөд цаашид өргөжүүлэх, шинэ базальт фибер материалын зах зээлд түлхэцтэй нэвтрэх төлөвлөгөөгөө хуваалцаж байгаадаа баяртай байна.

Бидний ирээдүйн алсын хараа нь шинэ бүтээгдэхүүн боловсруулах, зах зээлийг өргөжүүлэх, тогтвортой байдлын зорилтуудыг тасралтгүй эрэлхийлэх явдал юм. Бид зах зээлийн манлайлал, дэвшилтэт технологи, тогтвортой хөгжилд үнэнч хэвээр байгаа бөгөөд бидний санаачилга манай салбар болон дэлхийн байгаль орчны хариуцлагад цаашид ч эерэгээр нөлөөлнө гэдэгт итгэлтэй байна.

Чин сэтгэлээсээ,

А.Энхгэрэл



КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА



Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Үйл ажиллагааны чиглэл:

Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрлэл

Байгуулагдсан огноо:

2007

Хаяг:

Монгол улс,
Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 7 давхар

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Утас, и-майл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn

Үйлдвэрийн хүчин чадал:
Цагт 2.5 тн



Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн дарга:

Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

78



Хувьцааны мэдээлэл

Хувьцааны симбол код:

MSE:MBW / 544

МХБиржид бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан хувьцаа:

56,417,000 ширхэг

БИДНИЙ ТУХАЙ

“МОНГОЛ БАЗАЛЪТ” ХК нь Монголын хүнд аж үйлдвэрийн салбараас анхны Байгаль орчин нийгэм засаглалын үнэлгээ /ESG/ хийлгэсэн, дэлхийн аж үйлдвэрийн IV хувьсгал, хөгжлийн тэргүүлэх чиглэлд судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж, шинэ технологи, инновацийн шийдэл бүхий үйлдвэрлэлийг нэвтрүүлэн, хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хүлэмжийн хий, агаарын бохирдол, эрчим хүчний зардал, дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр олон зорилтот төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний томоохон үйлдвэрлэгч юм.



БАЗАЛЪТ чулууны 7 гайхамшиг : Бидний бүтээгдэхүүний цөмд байгалийн чулууны хүч оршино.



Бид галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тогтвортой нийгмийг бий болгох шинэ боломжийг үргэлж эрэлхийлдэг.



Эрхэм зорилго

Монголдоо Ногоон барилгын бүтээн байгуулалтын чанар стандартыг хөгжүүлнэ:

Базальт чулуунаас үйлдвэрлэгдэх бүхий л инновацийн технологийг нутагшуулна.

Тогтвортой хөгжлийг түүчээлнэ: Үндэсний хэмжээнд байгаль орчинд ээлтэй барилгын туршлагуудыг нэвтрүүлж, CO2 ул мөр бага үйлдвэрлэлийг дэмжинэ.

Бие даасан, хараат бус Эргэлтэт Эдийн Засгийн бүтээлцэнэ:

Импортын бүтээгдэхүүнээс хараат байдлыг зогсоож, үндэсний аж үйлдвэрүүдийн дэмжих бодлогыг идэвхижүүлнэ.



Алсын хараа

Ирээдүй хойч үедээ үлдээх, Эрүүл Ногоон Хотын төлөө:

Монголынхоо хөрсөнд бойжсон галт уулын БАЗАЛЪТ чулууны гайхамшигийг хамгийн орчин цагийн Инноваци Технологиор нээж, ЭРЧИМ ХҮЧНИЙ хараат бус, ГАЛ, УСНЫ эрсдэлгүй, Тогтвортой, Тэсвэртэй Ногоон Хотыг бүтээлцэнэ.

Нэгдсэн удирдлагын Бодлого (IMS)

Инновацийг Түүчээлнэ: Бид Монголын дулаалгын үйлдвэрлэлийн салбарт хамгийн сүүлийн үеийн бүтээгдэхүүн болон процесс нэвтрүүлэн ажлуулж байна.

Ямагт Тэргүүлэх ЧАНАР: Бид чулуун хөвөн дулаалгын үндэсний стандартыг тогтоосон.
Оролцогч талуудын үнэ цэнэ: Бид хөрөнгө оруулагч, харилцагч, ажилчид болон улсын нийгмийн хэрэгцээг нэн тэргүүнд тавьдаг.

Байгаль орчны менежмент: Бид хойч үедээ зориулж Монголын байгалийн баялгийг хамгаалдаг.

БҮТЭЭГДЭХҮҮН



Өнгөрсөн 17 жилийн турш бид өөрсдийн know-how болон мятрашгүй хөгжих хүсэл элмэлзэлээ, хийсэн бүхэндээ шингээж ирсэн. Бидний үүсгэн байгуулагч нар болон хамт олон хуучин арга техникийг тогтмол сорин, шинэлэг санааг туршин хөгжүүлдэгийн үр дүнд бид өнөөдөр байгалийн ганц чулуунаас олон төрлийн дэвшилтэт шийдлүүдийг гарган авсан байна.


Дэлхий дээрх бүх галт уулын чулуулгийн 90 гаруй хувь нь базальт юм. Базальт нь ихэвчлэн цахиур, төмөр, магни, кали, хөнгөн цагаан, титан, кальцийн оксидуудаас бүрддэг. Базальт чулууг цельсийн 2000 градусын температурт хайлуулж базальт чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалыг үйлдвэрлэдэг тул энэхүү материал нь 100% байгалийн гаралтай, байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, Монгол улсаас ОУ-ын галын А1 зэрэглэлд ордог цор ганц бүтээгдэхүүн юм.

Компани өөрийн уурхайгаас олборлосон түүхий эд Базальт чулууг ашиглан 30-150 кг/м³ эзэлхүүний масстай, 0,032-0,048 Вт/м дулаан дамжуулалтын итгэлцүүр бүхий 4 төрлийн дулаан тусгаарлагч бүтээгдэхүүн, базальт фибер арматур, нийт 4 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.



BASALTWOOL

чулуун хөвөн дулаан тусгаарлагч материал



BASALT REBAR

базальт фибер арматур



BASALT SANDWICH BOARD

базальт хэсэгчилэн угсрах кассет сэндвич хавтан



SPRAY BASALT

Шүршдэг болон үртсэн базальт дулаан тусгаарлагч материал

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



ХҮЧИН ЧАДЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ, ЗАХ ЗЭЭЛД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

ЕСБХБ-ны Олон улсын зөвлөх хөтөлбөртэй хамтран ажилласан нь Монгол Базальт ХК-ийн үйлдвэрлэлийн хүчин чадал, зах зээлд үзүүлэх нөлөөллийг мэдэгдэхүйц өргөжүүлэх, нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд олгосон туршлага, удирдамжийг ашигласнаар үйлдвэрлэлийн хүчин чадал

үр дүнтэй хоёр дахин нэмэгдэж, компанийг мэдэгдэхүйц өсөлт, зах зээлд манлайлах байр суурийг бий болгосон. Энэхүү өсөлт нь зах зээлийн өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаад зогсохгүй стратегийн зөвлөгөө, мэдлэг дамжуулах замаар хамтын ажиллагаа нь компанид шинэлэг технологи, үйл ажиллагааны сайжруулалтыг хэрэгжүүлэх боломжийг олгосон бөгөөд үүний үр дүнд үйлдвэрлэлийн хүчин чадал өссөн.



УДИРДЛАГЫН НЭГДСЭН ТОГТОЛЦООНЫ ИЖ БҮРЭН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Монгол Базальт ХК нь компанийн тогтвортой хөгжил, дэвшилтэт технологи, зах зээлийн манлайлын төлөө амлалтыг хангах зорилгоор ISO 9001, 14001, 45001 нэгдсэн удирдлагын тогтолцооны иж бүрэн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлсэн. Энэхүү сургалтын санаачилга нь 100 хувь байгалийн базальт чулуунаас үйлдвэрлэсэн

BASALTWOOL дулаалгын шинэлэг бүтээгдэхүүнээ ашиглан галын аюулгүй байдал, эрчим хүчний хэмнэлт, тав тухыг хангах тогтвортой шийдлүүдийг хангах компанийн эрхэм зорилготой нийцэж байна.

Хөтөлбөрийн тойм

Сургалтын хөтөлбөр нь чанарын удирдлагын ISO 9001, байгаль орчны менежментийн ISO 14001, хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын ISO 45001 стандартыг багтаасан нэгдсэн удирдлагын тогтолцооны нарийвчилсан асуудлуудыг судалдаг. Энэхүү хөтөлбөр нь ажилчдад үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах мэдлэг ур чадварыг эзэмшүүлэх юм.

Сургалтын модулиуд

Хөтөлбөр нь ISO стандарт бүрийн үндсэн зарчмууд, практик хэрэгжүүлэх стратеги, эрсдэлийн үнэлгээ ба нөлөөллийг бууруулах, тогтвортой байдал ба байгаль орчны зорилтууд, үйл ажиллагааны хүрээ, инноваци ба технологийн хөгжил, байгууллагын хөгжлийн төлөвлөгөөг багтаасан модулиудаас бүрдэнэ.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНГИЙН ТОЙМ



БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛДВЭРЛЭЛ

2023 оны 4 дүгээр улирлын байдлаар 3000 тонн хөвөн үйлдвэрлэлээ. Термобазальт шугам хоолойн дулаалгын цехэд нийт 4852 метр шугам, яндан хоолойн дулаалга хийж гүйцэтгэлээ.

Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрт их бүтээн байгуулалт засвар шинэчлэлийн ажил өрнүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.



ТАНИЛЦАХ ДАДЛАГА

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛИЙН, Барилгын материал үйлдвэрлэл технологийн ангийн 1, 2-р курсын оюутанууд МОНГОЛ БАЗАЛТ ХК-ийн үйлдвэрийн технологи болон үйл ажиллагааны зарчимтай танилцах дадлага сургалт хийлээ.



ХАМТЫН АЖИЛЛАГАА

Монгол Базальт ХК нь 2022 онд ЕСБХБ-тай олон улсын техник, технологи, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ба ЕСБХБ-ны зөвлөх инженерүүдийг хүлээн авч уулзан инженер техникийн инновациор үйлдвэрлэлийн өртөгийг 20-30% бууруулах боломжтой болсон ба 2023 онд бүтээгдэхүүнүүдийн үнийг **30-51%** буурууллаа.

БНХАУ-ын чулуун хөвөнгийн RWOOL үйлдвэрийн инженерүүдийг урьж, хамтарсан сургалт судалгаа, туршилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэн, базальт чулуун хөвөнгийн үйлдвэрийн хүчин чадлыг 50% нэмэгдүүлж, цагийн гарц **2.5 тн/цагт** хүрлээ.



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОЙМ

Монгол Базальт ХК нь 2023 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажиллалаа.

Үйлдвэрлэлийн шинэчлэл инновацийн үр дүнд чулуун хөвөн хавтангийн борлуулалтын үнээ **30-51%** бууруулан хэрэглэгчдэд хүргэж байна.

2023 онд борлуулалтын орлого **10 тэрбум** төгрөг болж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй хэдий ч нийт ашгийн маржин **4%-иар** өсч, **31%-д** хүрсэн бол цэвэр ашгийн маржин **2 дахин** өсч, **2.8 тэрбум** төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Монгол Базальт ХК нь 2022 онд ЕСБХБ-тай олон улсын техник, технологи, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ба 2023 онд ЕСБХБ-ны зөвлөх инженерүүдийг хүлээн авч уулзан инженер техникийн инновациор бүтээгдэхүүний өртөгийг **20-30%** бууруулах боломжтой болсон

Монгол Базальт ХК нь 2023 онд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд **3000** тн орчим бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 49.7%-ийг базальт лайт, 19.1%-ийг базальт хауз, 16.9%-ийг базальт вэнт фасад, 14.3%-ийг базальт техно стандарт марк тус тус эзэлж байна.

Санхүүгийн үзүүлэлт

График 1. тэрбум төгрөгөөр



График 2. тэрбум төгрөгөөр



График 3. тэрбум төгрөгөөр




График 4. Боодлын тоогоор





График 5. 1м3-ийн үнээр



Сангийн сайдын 2017 оны
361 дүгээр тушаалын
3 дугаар хавсралт

Регистрийн дугаар : 5112494

Хаяг :

Шуудангийн хаяг :

Утас : 99026691 Факс :

Өмчийн хэлбэр : Хувийн /монгол/ 100 хувь



**“Монголбазалт Хувьцаат компани”-ИЙН
2023 ОНЫ ЖИЛИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Хянаж хүлээн авсан байгууллагын нэр	Огноо	Мэргэжилтэн
Сангийн Яам	2024-03-21 20:36:23	/Э.Буянхишиг/



“Монголбазальт Хувьцаат компани”-ийн
2023 ОНЫ ЖИЛИЙН санхүүгийн тайлангийн
бодит байдлын тухай мэдэгдэл

2024 оны 3 сарын 18 өдөр

Захирал А.ЭНХГЭРЭЛ, ерөнхий нягтлан бодогч Б.БОЛОРТУЯА .бид манай аж ахуйн нэгжийн 2023-12-31 өдрөөр тасалбар болгон гаргасан санхүүгийн тайланд тайлант хугацааны үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдлыг “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18.1 дэх заалтын дагуу үнэн зөв, бүрэн тусгасан болохыг баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв тусгасан
6. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай байгууллагын албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Захирал

/А.ЭНХГЭРЭЛ/

Ерөнхий нягтлан бодогч

/Б.БОЛОРТУЯА/

Хэвлэсэн огноо: 2024 оны 3 сарын 22 өдөр

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

“Монголбазальт Хувьцаат компани”

2024 оны 3 сарын 22 өдөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл			2. Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр/
	1.1. Өмнөх үлд	1.2. Зөрүү	1.3. Эхний үлд	
1. ХӨРӨНГӨ				
1.1 Эргэлтийн хөрөнгө				
1.1.1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,428,462,600.00	43.55	1,428,462,643.55	5,760,907,762.33
1.1.2 Дансны авлага	323,206,500.00	79.01	323,206,579.01	11,528,170.06
1.1.3 Татвар, НДШ – ийн авлага	0.00	0.00	0.00	173,118.44
1.1.4 Бусад авлага	546,251,700.00	7.11	546,251,707.11	192,512,446.50
1.1.5 Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.1.6 Бараа материал	3,940,039,600.00	2.19	3,940,039,602.19	2,933,428,573.44
1.1.7 Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,327,909,700.00	- 68.82	1,327,909,631.18	2,822,862,258.79
1.1.8 Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.1.9 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
1.1.11 Эргэлтийн хөрөнгийн дүн	7,565,870,100.00	63.04	7,565,870,163.04	11,721,412,329.56
1.2 Эргэлтийн бус хөрөнгө				
1.2.1 Үндсэн хөрөнгө	16,848,678,400.00	- 0.16	16,848,678,399.84	18,099,192,849.66
1.2.2 Биет бус хөрөнгө	10,721,366,200.00	52.77	10,721,366,252.77	11,911,039,441.76
1.2.3 Биологийн хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.2.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00	0.00	1,945,863,146.22
1.2.5 Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.2.6 Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.2.7 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.2.8 Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
1.2.10 Эргэлтийн бус хөрөнгийн дүн	27,570,044,600.00	52.61	27,570,044,652.61	31,956,095,437.64
1.3 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	35,135,914,700.00	115.65	35,135,914,815.65	43,677,507,767.20
2. ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ				
2.1 Өр төлбөр				
2.1.1 Богино хугацаат өр төлбөр				
2.1.1.1 Дансны өглөг	342,516,000.00	- 30.55	342,515,969.45	245,144,177.18

2.1.1.2 Цалингийн өглөг	0.00	0.00	0.00	575,550.00
2.1.1.3 Татварын өр	887,809,500.00	- 35.18	887,809,464.82	1,329,657,233.48
2.1.1.4 НДШ - ийн өглөг	0.00	0.00	0.00	54,618.45
2.1.1.5 Богино хугацаат зээл	1,957,000,000.00	0.00	1,957,000,000.00	504,000,000.00
2.1.1.6 Хүүний өглөг	0.00	0.00	0.00	0.00
2.1.1.7 Ногдол ашгийн өглөг	0.00	0.00	0.00	729,846,100.00
2.1.1.8 Урьдчилж орсон орлого	1,171,490,200.00	51.40	1,171,490,251.40	488,447,013.25
2.1.1.9 Нөөц /өр төлбөр/	741,788,000.00	20.31	741,788,020.31	345,288,489.39
2.1.1.10 Бусад богино хугацаат өр төлбөр	4,145,400.00	95.32	4,145,495.32	3,078,159.02
2.1.1.11 Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
2.1.1.13 Богино хугацаат өр төлбөрийн дүн	5,104,749,100.00	101.30	5,104,749,201.30	3,646,091,340.77
2.1.2 Урт хугацаат өр төлбөр				
2.1.2.1 Урт хугацаат зээл	0.00	0.00	0.00	8,500,000,000.00
2.1.2.2 Нөөц /өр төлбөр/	0.00	0.00	0.00	0.00
2.1.2.3 Хойшлогдсон татварын өр	0.00	0.00	0.00	0.00
2.1.2.4 Бусад урт хугацаат өр төлбөр	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
2.1.2.6 Урт хугацаат өр төлбөрийн дүн	0.00	0.00	0.00	8,500,000,000.00
2.2 Өр төлбөрийн нийт дүн	5,104,749,100.00	101.30	5,104,749,201.30	12,146,091,340.77
2.3 Эздийн өмч				
2.3.1 Өмч:	5,641,700,000.00	0.00	5,641,700,000.00	5,641,700,000.00
2.3.1.1 - төрийн	0.00	0.00	0.00	0.00
2.3.1.2 - хувийн	5,641,700,000.00	0.00	5,641,700,000.00	5,641,700,000.00
2.3.1.3 - хувьцаат	0.00	0.00	0.00	0.00
2.3.2 Халаасны хувьцаа	0.00	0.00	0.00	0.00
2.3.3 Нэмж төлөгдсөн капитал	20,509,765,300.00	- 72.52	20,509,765,227.48	20,509,765,227.48
2.3.4 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	1,429,274,000.00	- 51.00	1,429,273,949.00	1,429,273,949.00
2.3.5 Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00	0.00	0.00
2.3.6 Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00	0.00	890,145,164.30
2.3.7 Хуримтлагдсан ашиг	2,450,426,300.00	137.87	2,450,426,437.87	3,060,532,085.65
	0.00	0.00	0.00	0.00
2.3.9 Эздийн өмчийн дүн	30,031,165,600.00	14.35	30,031,165,614.35	31,531,416,426.43
	0		5	3
2.4 ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	35,135,914,700.00	115.65	35,135,914,815.65	43,677,507,767.20
	0		5	0
1 Актив			35,135,914,815.65	43,677,507,767.20
			5	0
2 Пассив			35,135,914,815.65	43,677,507,767.20
			5	0
3 Зөрүү			0.00	0.00

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

“Монголбазальт Хувьцаат компани”

2024 оны 3 сарын 22 өдөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл			2. Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр/
	1.1. Өмнөх үлд	1.2. Зөрүү	1.3. Эхний үлд	
1. Борлуулалтын орлого (цэвэр)	14,212,925,100.00	67.91	14,212,925,167.91	10,019,108,280.58
2. Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	10,268,991,700.00	9.20	10,268,991,709.20	6,886,199,332.63
3. Нийт ашиг (алдагдал)	3,943,933,400.00	10,268,981,499.91	14,212,914,899.91	3,132,908,947.95
4. Түрээсийн орлого	0.00	0.00	0.00	0.00
5. Хүүний орлого	9,465,500.00	- 4.96	9,465,495.04	78,984,860.95
6. Ногдол ашгийн орлого	0.00	0.00	0.00	0.00
7. Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00	0.00	0.00
8. Бусад орлого	3,762,800.00	193.74	3,762,993.74	54,376,330.65
9. Борлуулалт, маркетингийн зардал	874,049,600.00	42.87	874,049,642.87	912,402,809.50
10. Ерөнхий ба удирдлагын зардал	772,904,700.00	- 19.36	772,904,680.64	441,373,948.41
11. Санхүүгийн зардал	213,115,400.00	63.64	213,115,463.64	530,890,212.86
12. Бусад зардал	17,603,600.00	11.47	17,603,611.47	7,670,000.00
13. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	118,090,200.00	11.81	118,090,211.81	- 4,680,321.00
14. Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00	0.00	0.00
15. Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00	0.00	0.00
16. Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00	0.00	0.00
17. Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00
18. Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	2,197,578,600.00	10,268,981,601.88	12,466,560,201.88	1,369,252,847.78
19. Орлогын татварын зардал	213,064,900.00	2.89	213,064,902.89	136,925,284.65
20. Ердийн үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	1,984,513,700.00	10,482,046,501.88	12,466,560,201.88	1,232,327,563.13
21. Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00
22. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	1,984,513,700.00	10,482,046,501.88	12,466,560,201.88	1,232,327,563.13
23. Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00
23.1 Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
23.2 Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
23.3 Бусад олз (гарз)	0.00	0.00	0.00	0.00
24. Нийт дэлгэрэнгүй орлогын дүн	1,984,513,700.00	10,482,046,501.88	12,466,560,201.88	1,232,327,563.13
25. Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	0.00	0.00	0.00	0.00

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

"Монголбазальт Хувьцаат компани"

2024 оны 3 сарын 22 өдөр

Үзүүлэлт	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	- 665,365,80 0.00	- 665,365,80 0.00
2. Залруулсан үлдэгдэл	5,641,700,0 00.00	0.00	20,509,765, 300.00	1,429,274,0 00.00	0.00	0.00	1,430,079,3 00.00	29,010,818, 600.00
3. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,984,513,7 00.00	1,984,513,7 00.00
4. Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
5. Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
6. Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	964,166,500 .00	964,166,500 .00
7. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
8. Эхний үлдэгдэл /төгрөгөөр/	5,641,700,0 00.00	0.00	20,509,765, 227.48	1,429,273,9 49.00	0.00	0.00	2,450,426,4 37.87	30,031,165, 614.35
8.1 Өмнөх үлд	5,641,700,0 00.00	0.00	20,509,765, 300.00	1,429,274,0 00.00	0.00	0.00	2,450,426,5 00.00	30,031,165, 800.00
8.2 Зөрүү	0.00	0.00	- 73.00	- 51.00	0.00	0.00	- 63.00	- 185.65
9. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
10. Залруулсан үлдэгдэл	5,641,700,0 00.00	0.00	20,509,765, 227.48	1,429,273,9 49.00	0.00	0.00	2,450,426,4 37.87	30,031,165, 614.35
11. Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	0.00	0.00	890,145,164 .30	1,232,327,5 63.13	2,122,472,7 27.43
12. Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
13. Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	506,118,084 .65	506,118,084 .65
14. Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	1,128,340,0 00.00	1,128,340,0 00.00
15. Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
16. Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/	5,641,700,0 00.00	0.00	20,509,765, 227.48	1,429,273,9 49.00	0.00	890,145,164 .30	3,060,532,0 85.65	31,531,416, 426.43

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

"Монголбазальт Хувьцаат компани"

2024 оны 3 сарын 22 өдөр

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл			2. Эцсийн үлдэгдэл / төгрөгөөр/
	1.1. Өмнөх үлд	1.2. Зөрүү	1.3. Эхний үлд	
1. Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
1.1 Мөнгөн орлогын дүн	16,502,503,700.00	80.80	16,502,503,780.80	10,239,727,117.98
1.1.1 Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	16,502,503,700.00	80.80	16,502,503,780.80	10,239,727,117.98
1.1.2 Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00	0.00	0.00
1.1.3 Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00	0.00	0.00
1.1.4 Буцаан авсан албан татвар	0.00	0.00	0.00	0.00
1.1.5 Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00	0.00	0.00
1.1.6 Бусад мөнгөн орлого	0.00	0.00	0.00	0.00
1.2 Мөнгөн зарлагын дүн	15,663,251,100.00	102.12	15,663,251,202.12	12,338,272,969.83
1.2.1 Ажиллагчдад төлсөн	1,175,858,300.00	27.59	1,175,858,327.59	1,418,697,039.20
1.2.2 Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	335,458,200.00	28.57	335,458,228.57	424,238,186.47
1.2.3 Бараа материал худалдан авахад төлсөн	11,486,923,900.00	26.61	11,486,923,926.61	9,212,103,864.80
1.2.4 Ашиглалтын зардалд төлсөн	65,438,900.00	10.16	65,438,910.16	22,898,674.99
1.2.5 Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	79,424,300.00	22.72	79,424,322.72	4,376,512.98
1.2.6 Хүүний төлбөрт төлсөн	169,028,800.00	13.64	169,028,813.64	350,586,314.63
1.2.7 Татварын байгууллагад төлсөн	1,877,820,200.00	- 30.55	1,877,820,169.45	651,835,555.72
1.2.8 Даатгалын төлбөрт төлсөн	20,178,700.00	- 28.00	20,178,672.00	20,588,450.00
1.2.9 Бусад мөнгөн зарлага	453,119,800.00	31.38	453,119,831.38	232,948,371.04
1.3 Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	839,252,600.00	- 21.30	839,252,578.70	- 2,098,545,851.85
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
2.1 Мөнгөн орлогын дүн	9,465,500.00	- 4.96	9,465,495.04	78,984,860.95
2.1.1 Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	0.00	0.00
2.1.2 Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	0.00	0.00
2.1.3 Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00	0.00	0.00
2.1.4 Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00	0.00	0.00
2.1.5 Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	0.00	0.00	0.00

2.1.6 Хүлээн авсан хүүний орлого	9,465,500.00	- 4.96	9,465,495.04	78,984,860.95
2.1.7 Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
2.2 Мөнгөн зарлагын дүн	540,576,500.00	6.00	540,576,506.00	215,743,821.35
2.2.1 Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	540,576,500.00	6.00	540,576,506.00	215,743,821.35
2.2.2 Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	0.00	0.00
2.2.3 Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	0.00	0.00
2.2.4 Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00	0.00	0.00
2.2.5 Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	0.00	0.00	0.00
	0.00	0.00	0.00	0.00
2.3 Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 531,111,000.00	- 10.96	- 531,111,010.96	- 136,758,960.40
3. Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ				
3.1 Мөнгөн орлогын дүн	18,298,913,500.00	105.82	18,298,913,605.82	9,783,321,121.03
3.1.1 Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	18,178,569,400.00	11.44	18,178,569,411.44	9,786,847,043.00
3.1.2 Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00	0.00	0.00
3.1.3 Төрөл бүрийн хандив	0.00	0.00	0.00	0.00
	120,344,100.00	94.38	120,344,194.38	- 3,525,921.97
3.2 Мөнгөн зарлагын дүн	23,142,697,400.00	7.65	23,142,697,407.65	3,215,571,190.00
3.2.1 Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	22,119,541,700.00	- 29.47	22,119,541,670.53	2,892,000,000.00
3.2.2 Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00	0.00	1,500,000.00
3.2.3 Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00	0.00	0.00
3.2.4 Төлсөн ногдол ашиг	1,020,901,700.00	54.55	1,020,901,754.55	320,916,790.00
	2,254,000.00	- 17.43	2,253,982.57	1,154,400.00
3.3 Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	- 4,843,783,900.00	98.17	- 4,843,783,801.83	6,567,749,931.03
3.4 Валютын ханшийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
4. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	- 4,535,642,300.00	65.91	- 4,535,642,234.09	4,332,445,118.78
5. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,964,104,900.00	- 22.34	5,964,104,877.66	1,428,462,643.55
6. Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,428,462,600.00	43.55	1,428,462,643.55	5,760,907,762.33
1 БЦМГ /1,3+2,3+3,3+4/			- 4,535,642,234.09	4,332,445,118.78
2 БЦМГ /6-5/			- 4,535,642,234.11	4,332,445,118.78
3 Зөрүү			0.00	0.00

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2023 оны 04 сарын 17-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Дугаар 02 тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг сонгож, баталгаажуулсан ба Компанийн тухай хууль, Компанийн дүрэмд зааснаар үйл ажиллагаа явуулж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Л.Ариунболд

ТУЗ-ийн дарга



Б.Шаравсамбуу



Хан Гю Бунг



П.Сайнбилэг



Г.Ганзориг



А.Энхгэрэл

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Ш.Энхтөр



П.Нямдорж



Ч.Зоригтбаатар

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ нь 2023 онд танхимаар, танхим цахим хосолсон, эчнээ санал хураалтын хэлбэрээр нийт 6 удаа ирц бүрэн хуралдаж, 21 тогтоол, шийдвэр гаргасныг дэлгэрэнгүй танилцуулбал:

Хурал	Тогтоолын агуулга	Огноо	Дугаар
1	2023 оны Бизнес төлөвлөгөө батлах тухай	2023.02.13	01
	Компанийн 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай	2023.02.13	02
	Ногдол ашиг хуваарилах тухай	2023.02.13	03
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	2023.03.07	04
3	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай	2023.05.01	05
	ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүн батлах тухай	2023.05.01	06
	ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хорооны бүрэлдэхүүн батлах тухай	2023.05.01	07
	ТУЗ-ийн дэргэдэх эрсдлийн удирдлагын хороо байгуулах тухай	2023.05.01	08
	ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны бүрэлдэхүүн сонгох тухай	2023.05.01	09
	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга томилох тухай	2023.05.01	10
4	Зөвшөөрөл олгох тухай	2023.05.24	11
5	Бизнесийн ёс зүйн дүрэм батлах тухай	2023.07.28	12
	Эрсдлийн удирдлагын хорооны журам батлах тухай	2023.07.28	13
	Гүйцэтгэх захиралд ээлжийн амралт олгох тухай	2023.07.28	14
	Эрсдлийн удирдлагын бодлого батлах тухай	2023.07.28	15
	Бодлогын баримт бичгүүд батлах тухай - Залгамж халааны бодлого - Цалин урамшууллын бодлого - Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого	2023.07.28	16
6	Барааны тэмдэг ашиглуулах лицензийн гэрээ байгуулах зөвшөөрөл олгох	2023.12.09	17
	Зөвшөөрөл олгох тухай	2023.12.09	18
	Зөвшөөрөл олгох тухай	2023.12.09	19
	Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай	2023.12.09	20
	Хөндлөнгийн аудитын байгууллагын гэрээг шинэчлэн батлах тухай	2023.12.09	21

Компанийн үйл ажиллагааны онцлог, одоогийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд ТУЗ-ийн гишүүдэд зориулан ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар удирдан “Компанийн засаглалын кодекс, түүний ач холбогдол” сэдэвт семинар, Ризиленс консалтинг ХХК-тай хамтран Нэгдсэн удирдлагын тогтолцооны стандартууд ISO9001, ISO14001, ISO 45001 танилцуулах болон “Бизнес ба хүний эрх” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулсан болно.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Компанийн тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, Компанийн засаглалын кодексыг удирдлага болгон ТУЗ-ийн дэргэд Аудитын, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын хороо ажилладаг ба 2023 онд Эрсдлийн удирдлагын хороог 5 гишүүнтэйгээр шинээр байгуулан ажиллаж байна.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн П.Нямдорж, гишүүдээр Г.Ганзориг, Ч.Зоригтбаатар нар тус тус сонгогдон ажиллаж байгаа ба 2023 онд 2 удаа ирц бүрэн хуралдаж “Компанийн залгамж халааны бодлого”-ын төсөл боловсруулж ТУЗ-өөр батлуулсан болно.

Залгамж халааны бодлого нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, гүйцэтгэх захирал болон бусад түлхүүр албан тушаалтан, инженерүүд, ажилтнуудын залгамж халааг урьдчилан бэлтгэх, хөгжүүлэх бодлогыг тодорхойлоход оршино.

Мөн нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж ТУЗ-ийн гишүүдийн үйл ажиллагааг үнэлж, дүгнэх системийг бүрдүүлсэн болно. Мөн нэр дэвшүүлэх хорооноос компанийн “Бизнесийн ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн найруулж ТУЗ-ийн 2023.07.28-ны өдрийн 12 дугаартай тогтоолоор батлуулж, үйл ажиллагаанд дагаж мөрдөх зөвлөмжийг гаргасан болно.

Бизнесийн ёс зүйн дүрмийг зөвхөн ажлын байранд байхдаа мөрдөх биш өөрийн ажил үүргийг гүйцэтгэх, компанийг төлөөлөх бүхий л цаг хугацаанд аливаа үйлдэл хийхэд анхаарах зүйлсийн үндсэн зарчмуудыг тусган оролцогч талууд нийтээр дагаж мөрдөхөөр зохицуулсан болно.

Мөн Компани ажилтнуудын болон оролцогч талуудын ШҮГЭЛ ҮЛЭЭСЭН мэдээллийг хүлээн авч, зохих журмын дагуу шалган шийдвэрлэх зарчмыг тусгаж, Шүгэл үлээх нь зүй ёсны үйлдэл бөгөөд шүгэл үлээсэн ажилтан, бусад этгээдийг шүгэл үлээснийх нь төлөө ямар нэгэн хариуцлага хүлээлгэхгүй байх ёс зүйг баримтлахаар баталгаажуулсан.

Аудитын хороо

Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ч.Зоригтбаатар, гишүүдээр Б.Шаравсамбуу, Ш.Энхтөр нар ажиллаж байгаа ба Аудитын хороо нь 2023 онд 3 удаа ирц бүрэн хуралдаж дараах асуудалд санал, зөвлөмж гарган ТУЗ-өөр батлуулсан болно. Үүнд:

- 1.Компанийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийх “Нексия глобал монголиа аудит” ХХК-тай байгуулах гэрээний төсөл баталгаажуулах
- 2.Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл, хэлцлийн төслийг хянаж боловсруулах
- 3.Аудитын хорооны үйл ажиллагааны журамд нэмэлт өөрчлөлт оруулах
- 4.“Сонирхлын зөрчилтэй хэлцлийг шийдвэрлэх журам” төсөл шинэчлэх боловсруулж, батлуулах

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь 2023 онд барааны тэмдэг ашиглуулах лицензийн гэрээ байгуулах, Термобазальт ХХК-д бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулах сонирхлын зөрчил бүхий хэлцэл хийх эрх олгох ТУЗ-ийн шийдвэрт санал, зөвлөмж өгч шийдвэрлүүлсэн байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүн Ш.Энхтөр, гишүүдээр П.Сайнбилэг, П.Нямдорж нар ажиллаж байна. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь 2023 онд 2 удаа ирц бүрэн хуралдаж “Цалин урамшууллын бодлого”-ын төсөл боловсруулж ТУЗ-өөр батлуулсан болно.

Цалин урамшууллын бодлого нь Компанийн хэмжээнд баримтлах цалин хөлс, урамшууллын зарчмыг тодорхойлж, ТУЗ, гүйцэтгэх захирал, ажилтнуудын цалин хөлс, урамшууллын тогтолцооны үндсийг тогтооход чиглэгдэнэ. Компани нь өөрийн цалин урамшууллын тогтолцоонд дараах суурь зарчмыг баримтална. Үүнд:

- Бизнесийн стратегитай уялдуулах – урт хугацааны өсөлтийг бий болгож, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдад хүртээх ашгийг нэмэгдүүлэх, компанийн үнэ цэнийг өсгөх стратеги бодлоготой цалин хөлсний тогтолцоог уялдуулан тодорхойлно.

- Өрсөлдөхүйц байх – Бид мэргэшсэн, өндөр ур чадвартай ажилтнуудыг сонгон шалгаруулж, тогтвор суурьшилтай ажиллуулахад шаардлагатай цалин хөлс, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлнэ.

- Гүйцэтгэлд суурилах – Ажлын гүйцэтгэлийн тодорхой хэмжигдэхүйц зорилго тавьж, гүйцэтгэлийг шударгаар үнэлэн урамшуулал олгоно.

- Хүний хөгжилд анхаарах – Ажилтнуудын карьерийн ахиц дэвшил, хувь хүний хөгжилд анхаарч, албан тушаал дэвших, тасралтгүй суралцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

ТУЗ-ийн гишүүд нь тогтмол үндсэн цалин хөлстэй байх ба нэмэгдэл урамшууллыг Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан хэмжээнд ТУЗ-ийн шийдвэрээр олгож болно. Гүйцэтгэх захирлын цалин хөлс, урамшууллын хэмжээг ТУЗ-тэй байгуулсан гэрээний үндсэн дээр шийдвэрлэх ба компанийн үйл ажиллагааны үр дүн, ашигт ажиллагаанаас хамаарч урамшуулал олгох эсэхийг ТУЗ шийдвэрлэнэ.

Нийт ажилтнуудын цалин, урамшууллын хэмжээг гүйцэтгэх захирлын тушаалаар баталж, мөрдөх ба үндсэн цалин, бүтээмжийн нэмэгдэл, хууль тогтоомжид заасан нэмэгдэл хөлс зэргээс бүрдэнэ.

Эрсдлийн удирдлагын хороо

Компанийн засаглалын кодексыг удирдлага болгон компанийн тогтвортой хөгжлийг хангах зорилгоор 2023 оноос эрсдлийн удирдлагын хороог ТУЗ-ийн дэргэд 5 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр шинээр байгуулсан ба хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус гишүүд Ч.Зоригтбаатар, гишүүдээр Л.Ариунболд, А.Энхгэрэл, Б.Шаравсамбуу, П.Нямдорж нар тус тус ажиллаж байна.

Эрсдлийн удирдлагын хороо нь компанийн стратегийн болон үйл ажиллагааны зорилго, зорилтоо биелүүлэх явцад учрах эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах, эрсдлийн улмаас гарах алдагдлыг хамгийн бага түвшинд байлгах, түүнээс үр ашигтай гарах замаар эрсдлийн удирдлагын тогтолцоог бүрдүүлэх бодлогыг тодорхойлох, хянах замаар биезбизнесийн тогтвортой хөгжлийг хангах үндсэн чиг үүрэгтэй байна.

Эрсдлийн удирдлагын хороо нь нийт 3 удаа ирц бүрэн хуралдаж дараах санал, төслүүдийг ТУЗ-д танилцуулан, батлуулсан болно.

- 1.“Компанийн эрсдлийн удирдлагын бодлого” боловсруулж, батлуулах
- 2.Эрсдлийн удирдлагын хорооны үйл ажиллагааны журам боловсруулж, батлуулах
- 3.“Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого” боловсруулж, батлуулах

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ

Монгол Базальт ХК-д учирч болзошгүй санхүү, үйл ажиллагаа, зах зээл, геополитикийн эрсдэлийг тодорхойлох, Эрсдэлийн ангилал тус бүрээр төрөлжүүлэх, дүрэм журмыг дагаж мөрдөх, аюулгүй байдлын протокол, геополитикийн эрсдэлийн даатгал зэрэг тактикуудыг бууруулах стратегийг энэ хэсэгт тодорхойлсон болно.

Монгол Базальт ХК-ийн эрсдэлийн үнэлгээ нь санхүү, үйл ажиллагаа, зах зээл, геополитикийн элементүүд зэрэг янз бүрийн ангиллыг хамардаг. Ангилал бүр нь компанийн тогтвортой өсөлт, ашигт ажиллагааг хамгаалахын тулд нөлөөллийг бууруулах тусгай стратеги шаарддаг өвөрмөц эрсдэлийг бий болгодог.

САНХҮҮГИЙН ЭРСДЭЛ



Инфляци ба валютын хэлбэлзэл

Бууруулах: Валютын хэлбэлзлийн нөлөөллийг бууруулах, эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайтар хянах зорилгоор эрсдэлээс хамгаалах стратегийг хэрэгжүүлнэ.



Санхүүжилт ба хөрвөх чадварын эрсдэл

Бууруулах: Санхүүжилтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх, зээлдүүлэгчидтэй нягт харилцаатай байх, хөрвөх чадварыг хангахын тулд мөнгөн гүйлгээний удирдлагын хүчирхэг тогтолцоог бий болгоно.



Зах зээлийн хэлбэлзэл

Бууруулах: Хөрөнгө оруулалтын багцыг төрөлжүүлэх, дериватив бүтээгдэхүүнийг ашиглах замаар зах зээлийн тогтворгүй байдалд өртөх эрсдэлийг бууруулах эрсдэлийн удирдлагын бодлогыг боловсруулна.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ



Нийлүүлэлтийн сүлжээний тасалдал

Бууруулах: Альтернатив ханган нийлүүлэгчдийг тодорхойлж, хөгжүүлэх, чухал материалын нөөц бүрдүүлэх, нийлүүлэлтийн сүлжээний гэнэтийн төлөвлөгөөг бий болгоно.



Технологийн өөрчлөлт

Бууруулах: Салбарын чиг хандлагыг хянаж, технологийн дэвшлээс түрүүлэхийн тулд R&D-д хөрөнгө оруулалт хийж, өөрчлөлтөд хурдан дасан зохицох уян хатан байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.



Эрүүл мэнд, аюулгүй байдлын осол

Бууруулах: Аюулгүй байдлын хатуу протокол, тогтмол сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, ослын эрсдлийг бууруулахын тулд ажлын байрны аюулгүй байдлын технологид хөрөнгө оруулалт хийнэ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛ



Өрсөлдөөнт даралт

Бууруулах: Өрсөлдөгчдөд тогтмол дүн шинжилгээ хийж, бүтээгдэхүүний тасралтгүй инновацийг онцолж, хэрэглэгчийн сэтгэл ханамж, брэндийн үнэнч байдлыг нэмэгдүүлэхэд анхаарлаа хандуулна.



Зохицуулалтын өөрчлөлт

Бууруулах: Тусгай зохицуулалтын нийцлийн багийг ажиллуулж, хууль эрх зүйн шаардлагуудыг шинэчилж, зохицуулах байгууллагуудтай хүчтэй харилцаа холбоог бий болгоно.



Зах зээлийг өргөжүүлэх эрсдэл

Бууруулах: Зах зээлийн нарийвчилсан судалгаа хийж, зах зээлд шинээр нэвтэрч буй хүмүүсийг туршиж, үр дүнтэй нэвтрэхийн тулд орон нутгийн байгууллагуудтай стратегийн түншлэлийг хөгжүүлнэ.

ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ БА НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ СТРАТЕГИ



ГЕОПОЛИТИКИЙН ЭРСДЭЛ



Худалдааны саад ба тариф

Бууруулах: Экспортын зах зээлийг төрөлжүүлэх, дипломат сурталчилгаа хийх, олон улсын худалдааны бодлогын үр нөлөөг сайтар үнэлнэ.



Улс төрийн тогтвортой байдал

Бууруулах: Геополитикийн үзүүлэлтүүдийг хянаж, бизнесийн уян хатан стратегийг баримталж, улс төрийн эрсдэлийн даатгалын боломжуудыг судална.

Эдгээр болзошгүй эрсдлийг идэвхтэй шийдвэрлэж, санал болгож буй нөлөөллийг бууруулах стратегийг хэрэгжүүлснээр Монгол Базальт ХК нь зах зээл дэх байр сууриа бэхжүүлж, сорилтуудыг илүү үр дүнтэй даван туулж, тогтвортой өсөлт, ашигт ажиллагааг хангах боломжтой.

Дүгнэлт ба ирээдүйн төлөв байдал

Монгол Базальт ХК нь сүүлийн нэг жилийн хугацаанд янз бүрийн гол салбарт томоохон ахиц дэвшил гаргаж, тогтвортой үйл ажиллагаа, ажилчдын сургалт, судалгаа, хөгжил, үйлдвэрлэлийн үр ашгийн чиглэлээр мэдэгдэхүйц ахиц дэвшил гаргасан байна. Тогтвортой хөгжил, технологийн шинэчлэл, зах зээлийн манлайллын төлөөх компанийн тууштай байдал нь ногоон төслүүд, түүхий эдийн тогтвортой эх үүсвэр, олон улсын технологийн хөгжил, судалгааны хүрээлэнгүүдтэй стратегийн түншлэлийн хүрээнд илт харагдаж байна.



BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.4 заалт, 47 дугаар зүйлийн 47.1 заалт, 76 дугаар зүйлийн 76.1.12 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.6.12 дах заалт, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны 02-р сарын 16-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол базальт” ХК-ийн 2023 оны жилийн эцсийн аудитын өмнөх санхүүгийн тайлангийн татварын дараах цэвэр ашиг болох 1,232,327,561.8 төгрөгөөс нэгж хувьцаанд 21 /хорин нэг/ төгрөг буюу нийт 1,184,757,000 төгрөгийн ногдол ашгийг хуваарилсугай.

2. Ногдол ашиг авах хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтоосугай.

3. Компанийн нийт гаргасан хувьцааны үндсэн 70% /39,491,900 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг компаниас, олон нийтэд нээлттэй 30% /16,925,100 ширхэг энгийн хувьцаа/-ийн хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв дэх дансанд 2024 оны 12 сарын 31-ний өдрийн дотор олгохыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тогтоолыг Монголын хөрөнгийн бирж, компанийн цахим хуудсаар дамжуулан нийт хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга /О.Билгүүн/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА




Л.АРИУНБОЛД

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ

Ногдол ашгийн журмын дагуу Компани нь хувьцаа эзэмшигчдийн оруулсан хөрөнгийг зүй зохистой захиран зарцуулж, ногдол ашгийн хэмжээг зохистой түвшинд байлгах бодлого баримтална.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 02 сарын 16-ны өдрийн 03 дугаартай тогтоолоор Компанийн 2023 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн 96.1 хувь буюу нийт 1,184,757,000 төгрөгийг ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн ба энэ нь нэгж хувьцаанд 21 төгрөг ногдохоор байна.

Ногдол ашгийн өсөлт /₮/



Ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%
2023	1,184,757,000.00	96.1%	21	10.2%

ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 242.68₮, доод ханш нь 175.31₮ бөгөөд 2023 оны 4 дүгээр улиралын хаалтын ханш 190.04₮ байлаа.



ХУВЬЦААНЫ ХАНШ

Хаалтын ханш
/2023.12.31/

+0.04₮

190₮



190.04₮

Өмнөх ханш
/2022.12.31/

5%-иас дээш хувьцаа эзэмшигчид:

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 208.3 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 2.5 сая ширхэг хувьцаа 531.2 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН КОДЕКСЫН ХЭРЭГЖИЛТ, ҮНЭЛГЭЭ

Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа нь засаглалын шинэчлэлтийг бий болгож, үр дүнд нь Компанийн засаглалын кодексын зарчмуудад нийцэж ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний зэрэглэл”-д **88,9** хувь буюу 109 хувьцаат компаниас **арван дөрөвт** эрэмблэгдсэн

№	Кодексын зарчим	Авбал зохих оноо	СЗХ Анхны үнэлгээ 2022.08	СЗХ Үнэлсэн оноо 2023.11.30	2023.01.01-ний байдлаар өөрийн үнэлгээ	
					Оноо	Хувь
1	ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	9	9	10	83.3%
2	ТУЗ-ийн дэргэдэх хороод тэдгээрийн чиг үүрэг	10	10	9	9	90%
3	Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	5	6	6	100%
4	Аудит, хяналтын тогтолцоо	6	5	6	6	100%
5	Эрсдлийн удирдлага	8	6	5	7	87.5%
6	Эрх бүхий албан тушаалтын цалин урамшуулал	6	5	6	6	100%
7	Оролцогч талуудын эрх ашиг	8	7	7	8	100%
8	Компанийн соёл	6	5	6	6	100%
9	Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	10	10	100%
	Нэгдсэн дүн	72	61	64	69	95.8%

Компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх хөтөлбөрийг, арга хэмжээний төлөвлөгөөг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 06 сарын 30-ны өдрийн 07 дугаартай тогтоолоор баталж, хэрэгжилтийг хангаж ажилласаар ирсэн ба 2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 95.8 /69 оноо/ хувь буюу Засаглал хэвийн буюу эрсдэлгүй үнэлгээтэй байна.





BASALTWOOL
МОНГОЛ БАЗАЛТ ХК

МОНГОЛ БАЗАЛТ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 02-р сарын 16-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Монгол базальт ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт гаргах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Компанийн дүрмийн 6-р бүлгийн 6.2.6.5 дах заалт, “Монгол Базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн тэмдэглэлийг үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДҮГНЭЛТ

“Монгол базальт” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдон дэргэдээ Нэр дэвшүүлэх хороо, Аудитын хороо, Цалин урамшууллын хороо болон Эрсдлийн удирдлагын хороог шинээр байгуулан ажиллаж байна. ТУЗ нь 2023 онд нийт 6 удаа 100 хувийн ирцтэйгээр хуралдаж, 21 тогтоол, шийдвэрээр компанийн хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлсэн бөгөөд “Залгамж халааны бодлого”, “Цалин урамшууллын бодлого”, “Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах бодлого”, “Эрсдлийн удирдлагын бодлого” болон “Бизнесийн ёс зүйн дүрэм” -ийг шинээр баталсан.

Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа нь засаглалын шинэчлэлтийг бий болгож, үр дүнд нь Компанийн засаглалын кодексын зарчмуудад нийцэж ажиллахад эерэг нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны “Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийн үнэлгээний зэрэглэл”-д 88,9 хувь буюу 109 хувьцаат компаниас арван дөрөвдүгээрт эрэмблэгдсэн явдал юм.

Компанийн тухай хууль, компанийн дүрэмд заасныг баримтлан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 02 сарын 13-ны өдрийн 01 дугаартай тогтоолоор “Монгол базальт ХК-ийн 2023 оны Бизнес төлөвлөгөө”-г баталсан бөгөөд хэрэгжилтийг дүгнэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна.

Манай үйлдвэр 2023 онд нийт 146,000 хүн/цаг ажиллаж 3000 орчим тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн ба 10,1 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 1,2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан болно.

“Монгол базальт” ХК нь тогтвортой хөгжил, дэвшилтэт технологи, зах зээлийн манлайллын төлөөх амлалтаа тэмдэглэж, өнгөрсөн онд томоохон үйл ажиллагааны эхлэлүүдийг тавьж чадсан. Үүнд:

-Европын сэргээн босголт хөгжлийн банкны олон улсын зөвлөх, үйлдвэрлэлийн нарийн мэргэжилтэнүүдийг урьж зөвлөгөө авсаны зэрэгцээ манай ИТА-ны баг ихээхэн хүчин чармайлт гарган ажилласны үр дүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг 2 дахин нэмэгдүүлж цагийн гарцыг 2,5 тоннд хүргэсэн

-Чанар, стандартын өндөр шаардлага хангасан чулуун хөвөн дулаалгын материалын үйлдвэрлэлийн өртөг, зардлыг багасган борлуулалтын үнийг 35 хувиар бууруулж, бүтээгдэхүүний зах зээлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлсэн

- Хүнд аж үйлдвэрийн салбараас анхдагч болж Байгаль орчин, нийгэм засаглал /ESG/-ийн суурь шинжилгээг амжилттай хийж дуусгасан нь цаашид тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад түлхэц өгсөн

-Нэгдсэн удирдлагын тогтолцооны ISO 9001, ISO 14001, ISO 45001 стандартуудыг цогцоор нь нэвтрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж, баталгаажуулах бэлтгэл хангасан

Компанийн стратеги зорилгодоо хүрч, тогтвортой өсөлтийг бий болгох үнэт зүйлсийн нэг бол хүний нөөц, түүний тогтвортой байдлыг хангах хөтөлбөр бөгөөд компани ажилтнуудын сургалт хөгжүүлэлт, мэргэшүүлэн бэлтгэх, эрүүл мэнд, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн. Мөн бүтээмжид суурилсан өрсөлдөхүйц цалин хөлсний бодлого нэвтрүүлсэн бөгөөд ажилтнуудын дундаж цалинг өнгөрсөн оныхоос 27.6 хувиар нэмэгдүүлсэн байна.

Бид зөвхөн үйлдвэрлэгч бус технологи хөгжүүлэгч болсныг илтгэж Нийслэл хотын экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, хүлэмжийн хий, агаарын бохирдлыг бууруулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд бодит дэмжлэг үзүүлж чадахуйц томоохон зорилтот хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь байгаль дахь БАЗАЛТ чулуунаас үйлдвэрлэгдэх бүхий л инновацийн технологийг нутагшуулах компанийн хөгжлийн хурдыг нэмэгдүүлсэн гэж үзэж байна.

“Монгол Базальт” ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь цаг үеийн нөхцөл байдалд тохируулан санхүү болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны оновчтой төлөвлөлт хийж 2023 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг бүрэн хангаж, компанийн тогтвортой хөгжилд түлхэц болохуйц олон төсөл хөтөлбөрийн суурийг тавьж “хангалттай сайн” ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ДҮРЭМД ОРУУЛАХ
НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН ТӨСӨЛ**

Бүлэг хэсэг	Одоо байгаа зохицуулалт	Өөрчлөн найруулсан зохицуулалт
6-р бүлэг 6.2.2	Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жил байна.	Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна.

Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулахын ач холбогдол

1. Компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого, стратеги зорилтыг хэрэгжүүлэхэд мэргэшсэн удирдлагын багийг тогтвортой ажиллуулах
2. “Залгамж халааны бодлого”-ын хэрэгжилтийг хангаж ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч чадварлаг, мэргэшсэн боловсон хүчинг бодлогоор бэлтгэх
3. Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирлын харилцан уялдаа холбоо бүхий үйл ажиллагаа, засаглалын шинэчлэлтийн үр дүнг бүрэн гаргах



2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ ТӨСЛҮҮДИЙН ХУРААНГУЙ

Шинэ үйлдвэрийн төсөл, үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэх

Монгол Базальт компанийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх, дулаалгын зах зээлд дээрх байр сууриа бэхжүүлэх стратегийн зорилтын дагуу 2025 оны эцэс гэхэд 30000тн/жил хүчин чадал бүхий шинэ үйлдвэр барихаар төлөвлөж байна.

Зах зээлийн тэлэлт

Бид зах зээлийг өргөжүүлэхийн тулд 2024 оны 2 дугаар улирал гэхэд стратегийн чухал газруудад агуулах түрээсэлэхээр төлөвлөж байна. Мөн бид төв азийн зах зээлд Базальт Чулуун хөвөн бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхээр төлөвлөн судалгаа хөгжүүлэлтийн ажлуудыг эхлүүлээд байна.

Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөө

Монгол Базальт ХК нь 2024 онд Базальт чулуун хөвөн дулаалгын материал, базальт арматурын үйлдвэрлэлийг тогтвортой явуулах ба Термобазальт ХХК, Грөвүүл ХХК-д базальт чулуун хөвөнг захиалгын дагуу үйлдвэрлэж, ханган нийлүүлнэ.

Чулуун хөвөн үйлдвэрлэлийн онцлогоос шалтгаалан тогтмол хугацаанд их засвар үйлчилгээ хийх шаардлагатай тул засварын горимд нийцүүлэн 1, 2-р сард үйлдвэрийн тоног төхөөрмжийн шинэчлэл, угсралт, урсгал засварын ажлыг хийж бусад саруудад үйлдвэр хэвийн ажиллах ба 2024 онд 5250 тн бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.



Нүүрсхүчлийн хийг бууруулах

Тус компани нь өөрийн үйл ажиллагааны болон барилгын салбараас ялгарч буй нүүрс хүчлийн хийг бууруулах тал анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд:

- Үйлдвэрийн барилгын төслөөс эхлүүлэн CO2 ул мөр бага байх үндэслэлийг тусгах
- Базальт файбер бүтээгдэхүүнийг цемент, бетон, гантай хольц хэрэглсэнээр буурах CO2 хэмжээг сурталчилан таниулах
- одоо байгаа үйлдвэрийн ялгаруулж буй CO-ийн хэмжээг бүртгэж хөтлөх, хянах
- Бүтээгдэхүүний хэмнэж буй CO2 хэмжээг тооцоолох зэрэг ажлуудыг төлөвлөсөн.

Тогтвортой хөгжлийн санаачилга

Тогтвортой байдлыг хангах амлалттайгаар тус компани байгальд ээлтэй дулаалгын шийдлүүдийг хэрэгжүүлж, нүүрстөрөгчийн ялгарал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулахад чиглэсэн BASALTCycle дахин боловсруулах хөтөлбөрийг санаачилан хэрэгжүүлнэ. Энэхүү төсөл нь тогтвортой хөгжлийн 12, 15, 13 дугаар зорилтуудыг бүрэн хангах юм.



2

0

5



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 сарын 19-ны өдрийн
04 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт



**“МОНГОЛ БАЗАЛТ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС**

Санал хураах арга: Энгийн

Хувьцаа эзэмшигчийн овог: _____

Хувьцаа эзэмшигчийн нэр: _____

Регистрийн дугаар: _____

Итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцож байгаа тохиолдолд

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр _____

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Брокерийн компанийн нэр: _____

**“Монгол базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 04 сарын 29-ны
өдрийн Даваа гаригийн 15.00 цагт**

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах			
2	“Монгол базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлого батлах			
3	“Монгол базальт” ХК-ийн дүрэмд оруулах нэмэлт өөрчлөлт батлах			

Хувьцаа эзэмшигч /итгэмжлэгдсэн төлөөлөгч/-ийн гарын үсэг _____ /

Санал авах хуудас үйлдсэн: 2024 оны __ сарын __ өдөр

Саналын хуудасыг хүчинтэйд тооцсон эсэх: _____

Тооллогын комиссын дарга _____ /Т.Ууганцэцэг/

Саналын хуудасыг хүчингүйд тооцсон шалтгаан: _____

Санамж:

- Хувьцаа эзэмшигч нь саналын хуудасыг бөглөхдөө санал өгөх хэсэгтээ +/- тэмдэглэгээ хийнэ. Жишээ нь: Зөвшөөрсөн бол зөвшөөрсөн хүснэгтэд +/- тэмдэглэгээ хийнэ.
- Санал авах хуудасны эхний хэсгийг зуучлагч үнэт цаасны компанийн тэмдэг даран баталгаажуулж хувьцаа эзэмшигчдэд өгнө.
- Засварласан, балласан залруулагатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
- Хувьцаа эзэмшигчид нь 2024 оны 04 сарын 26-ний дотор хурлын материалтай танилцах бөгөөд өөрийн биеэр оролцох боломжгүй тохиолдолд 2024 оны 04 сарын 26-ний 18.00 цагаас өмнө санал авах хуудсанд саналаа тэмдэглэн үйлчлүүлдэг үнэт цаасны компанидаа хүргүүлнэ.



Төсөл

“МОНГОЛ БАЗАЛЬТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 29-ны өдөр

№ 01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд
Төлөөлөн удирдах зөвлөлийн өгсөн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.1.5.11 дэх хэсэг, 2024 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 0-р сарын 29-ны өдөр

№ 02

Улаанбаатар хот

Компанийн дунд хугацааны хөгжлийн бодлого батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.15 дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.1.5.16 дах хэсэг, 2024 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. “Монгол Базальт” ХК-ийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх, бизнесийн тогтвортой байдлыг хангаж ажиллахад шаардлагатай мэргэжлийн удирдлагыг хэрэгжүүлж, зохих зөвлөмж, шийдвэрийг гаргаж байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Л.Ариунболд/-д зөвшөөрсүгэй.

3. “Монгол Базальт” ХК-ийн бизнес төлөвлөгөө, үйл ажиллагааны төлөвлөгөөг дунд хугацааны хөгжлийн бодлогод уялдуулан боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ



Төсөл

“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 04-р сарын 29-ны өдөр

№ 03

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1-дэх заалт, “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.1.5.1 хэсэг, 2024 оны 04 сарын 29-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол Базальт” ХК-ийн дүрмийн 6 дугаар бүлгийн 6.2.2 дах хэсгийн “2 жил” гэснийг “4 жил” болгон дараах байдлаар өөрчилсүгэй.

2. “Төлөөлөн удирдах зөвлөл нь 9 гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн 6 гишүүн нь ердийн, 3 гишүүн нь хараат бус гишүүн байна. ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байна”

3. Компанийн дүрэмд оруулсан нэмэлт өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлж, компанийн цахим хуудаст байршуулахыг Гүйцэтгэх захирал /А.Энхгэрэл/-д зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА

П.НЯМДОРЖ

*Маргаашийн хөгжил дэвшлийг
өнөөдөр хамтдаа бүтээнэ.*



 75114444, 77006768

 www.basaltwool.mn

 monbasalt@rockwool.mn